



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/543

Мандлаговь

Ажилчдыг шилжүүлэн авах комисс  
томилон ажиллуулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн өмчит "Нийтлэг үйлчилгээ" үйлдвэрийн газрын хооронд 2018 онд бүтээгдэхүүн нийлүүлж, санхүүжилт авах гэрээний 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн өмчит "Нийтлэг үйлчилгээ" үйлдвэрийн газартай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар тохиролцсон тул тус газрын үйлчилгээний албан хаагчдыг сонгон шалгаруулж, аймгийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлэн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Ц.Эрдэнэсүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Гишүүд: А.Ганбат (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)  
Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)  
Г.Самданцоодол (Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга)  
Б.Түвшинбаяр (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)  
Г.Бадамсүрэн (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)  
М.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)  
С.Цэнгэлмаа (Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)  
Д.Нандинцэцэг (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

Хоёр. Орон нутгийн өмчит "Нийтлэг үйлчилгээ" үйлдвэрийн газрын үйлчилгээний албан хаагчдыг сонгон шалгаруулж, аймгийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлэн авах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн чанартай зохион байгуулахыг комисс (Ц.Эрдэнэсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010670

